



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 280

Улаанбаатар хот

### Аргачлал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 77 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам”-ын 3.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үнэ, өгөөж, хүү тооцох болон арилжааны хуваарилалт хийх, Засгийн газрын дотоод үнэт цаасыг хоёрдогч зах зээлээс буцаан худалдан авах аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.


2. Энэ тушаалын хэрэгжилтийг хангаж, холбогдох байгууллагад хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар /Ц.Зоригтбат/-д, тушаалын биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Доржсэмбэд/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Арилжааны төлбөр тооцоо ХХК /О.Эрдэнэгэрэл/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус даалгасугай.



Ч.ХҮРЭЛБААТАР

**ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ, ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ, ӨГӨӨЖ, ХҮҮ ТООЦОХ БОЛОН АРИЛЖААНЫ ХУВААРИЛАЛТ ХИЙХ, ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСЫГ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛЭЭС БУЦААН ХУДАЛДАН АВАХ АРГАЧЛАЛ**



**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1. Энэ аргачлалыг Өрийн удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам”-ын зохицуулалтын хүрээнд ашиглана.
- 1.2. Энэ аргачлалд дурдсан нэр томъёог Өрийн удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам”-д тодорхойлсны дагуу, хууль, журамд тусгагдаагүй бусад нэр томъёог нийтлэг хэрэглэгддэг утгаар ойлгоно.
- 1.3. Нэгж үнэт цаасны үнэ, купон, өгөөжийг энэ аргачлалд заасан томъёогоор тооцож зуутын орноор нарийвчилна.
- 1.4. Засгийн газрын дотоод үнэт цаасны нийт үнэ болон купоны төлбөрийг тооцохдоо нэгж үнэт цаасны үнэ, купоныг үнэт цаасны нийт тоо ширхгээр үржүүлэн тооцно.
- 1.5. Засгийн газар хямдруулалттай (ЗГДҮЦ)-ны төлбөрийг арилжааны мэдэгдэлд заасан хугацааны эцэст нэрлэсэн дүнгээр төлөх бөгөөд хямдруулсан үнэ, өгөөжийн хувийг энэ аргачлалд заасан томъёогоор тооцоолно.
- 1.6. Засгийн газар купонтой үнэт цаасны купоны төлбөрийг арилжааны мэдэгдэлд заасны дагуу сар, улирал, хагас жилийн давтамжтай, үндсэн төлбөрийг үнэт цаасны хугацааны эцэст төлөх бөгөөд үнэ, өгөөж, купоныг энэ аргачлалд заасан томъёогоор тооцоолно.

**ХОЁР. ҮНЭ ТООЦОХ**

- 2.1. Засгийн газрын хямдруулалттай богино хугацаат дотоод үнэт цаасны үнийг дараах томъёогоор тооцно:

$$P_S = \frac{F}{(1+i_S \cdot \frac{t}{365})}$$

$P_S$  = ЗГДҮЦ-ны хямдруулсан үнэ

$F$  = ЗГДҮЦ-ны нэрлэсэн үнэ

$i_S$  = ЗГДҮЦ-ны өгөөжийн хувь, жилээр

$t$  = ЗГДҮЦ-ны хугацаа, өдрөөр

- 2.2. Засгийн газрын хямдруулалттай дунд буюу урт хугацаат дотоод үнэт цаасны үнийг дараах томъёогоор тооцно:

$$P_L = \frac{F}{(1+i_L)^T}$$

$P_L$  = ЗГДҮЦ-ны хямдруулсан үнэ

$F$  = ЗГДҮЦ-ны нэрлэсэн үнэ

$i_L$  = ЗГДҮЦ-ны өгөөжийн хувь, жилээр

$T$  = ЗГДҮЦ-ны хугацаа, жилээр

2.3. Засгийн газрын купонтой дотоод үнэт цаасны үнийг дараах томъёогоор тооцно.

$$P_C = C * \left( \frac{1 - \frac{1}{(1 + \frac{i_C}{n})^{Tn}}}{\frac{i_C}{n}} \right) + F * \left( \frac{1}{(1 + \frac{i_C}{n})^{Tn}} \right)$$

$P_C$  = ЗГДҮЦ-ны үнэ

$F$  = ЗГДҮЦ-ны нэрлэсэн үнэ

$C$  = Купон (ЗГДҮЦ-ны нэрлэсэн дүнгээс тодорхой хувиар тооцон тогтмол давтамжаар төлөх хүүний төлбөр)

$n$  = Нэг жилд купон төлөгдөх давтамжийн тоо

$T$  = ЗГДҮЦ-ны төлөгдөх өдөр хүртэлх хугацаа, жилээр

$i_C$  = ЗГДҮЦ-ны өгөөжийн хувь, жилээр (хөрөнгө оруулагчийн нэг жилд хүртэх ашгийн хувь)

2.4. Ялгавартай үнэтэй арилжааны үед өрсөлдөөнт санал ирүүлсэн арилжаанд оролцогчийн үнэт цаасны үнийг тооцоолохдоо тухайн оролцогчийн ирүүлсэн өгөөжийн хувийг, өрсөлдөөнт бус санал ирүүлсэн арилжаанд оролцогчийн үнэт цаасны үнийг тооцоолохдоо амжилттай биелсэн өрсөлдөөнт саналыг жигнэсэн дундаж өгөөжийн хувийг тус тус ашиглана.

2.5. Нэгдсэн үнэтэй арилжааны үед арилжаанд оролцогчийн үнэт цаасны үнийг тооцоолохдоо амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын хамгийн өндөр өгөөжийн хувийг ашиглана.

## ГУРАВ. ӨГӨӨЖ ТООЦОХ

3.1. Засгийн газрын хямдруулалттай богино хугацаат дотоод үнэт цаасны өгөөжийн хувийг дараах томъёогоор тооцно:

$$i_S = \left( \frac{F - P_S}{P_S} * \frac{365}{t} \right) * 100\%$$

$i_S$  = ЗГДҮЦ-ны өгөөжийн хувь, жилээр

$F$  = ЗГДҮЦ-ны нэрлэсэн үнэ

$P_S$  = ЗГДҮЦ-ны хямдруулсан үнэ

$t$  = ЗГДҮЦ-ны хугацаа, өдрөөр

3.2. Засгийн газрын хямдруулалттай дунд буюу урт хугацаат дотоод үнэт цаасны өгөөжийн хувийг дараах томъёогоор тооцно:

$$i_L = \left( \left( \frac{F}{P_L} \right)^{\frac{1}{T}} - 1 \right) * 100\%$$

$i_L$  = ЗГДҮЦ-ны өгөөжийн хувь, жилээр

$F$  = ЗГДҮЦ-ны нэрлэсэн үнэ

$P_L$  = ЗГДҮЦ-ны хямдруулсан үнэ

$T$  = ЗГДҮЦ-ны хугацаа, жилээр

3.3. Засгийн газрын купонтой дотоод үнэт цаасны өгөөжийг дараах томъёогоор тооцно:

$$i_C = \left( \frac{C + \frac{F - P_C}{T}}{\frac{F + P_C}{2}} \right) * 100\%$$

$i_C$  = ЗГДҮЦ-ны өгөөжийн хувь (шууд болон шууд бус оролцогчийн нэг жилд хүртэх ашгийн хувь)

$F$  = ЗГДҮЦ-ны нэрлэсэн үнэ

$P_C$  = ЗГДҮЦ-ны хямдруулсан үнэ

$C$  = ЗГДҮЦ-ны купон (ЗГДҮЦ-ны нэрлэсэн дүнгээс тодорхой хувиар тооцон тогтмол давтамжаар төлөх хүүний төлбөр)

$T$  = ЗГДҮЦ-ны үнэт цаасны хугацаа, жилээр

## **ДӨРӨВ. ХҮҮ ТООЦОХ**

4.1. ЗГДҮЦ-ны купоны төлбөрийг дараах томъёогоор тооцно.

$$C = F * \frac{c}{n}$$

$C$  = Нэг удаагийн купоны төлбөр

$F$  = Нэгж үнэт цаасны нэрлэсэн үнэ

$c$  = Купоны хувь, жилээр

$n$  = Нэг жилд купон төлөгдөх давтамжийн тоо

4.2. Засгийн газрын купонтой дотоод үнэт цаасны хуримтлагдсан хүүг дараах томъёогоор тооцно.

$$AI = \frac{C}{365} * (DD - SD)$$

*AI = Хуримтлагдсан хүү*

*C = Купон (ЗГДҮЦ-ны нэрлэсэн дүнгээс тодорхой хувиар тооцон тогтмол давтамжаар төлөх хүүний төлбөр)*

*SD = Хүү хуримтлуулах эхний өдөр*

*DD = Хүү хуримтлуулах сүүлийн өдөр*

## **ТАВ. АРИЛЖААНЫ ХУВААРИЛАЛТ ХИЙХ**

5.1. Үнэт цаас гаргагч нь нээлттэй хэлбэрээр арилжаалсан ЗГДҮЦ-ны хуваарилалтыг хийхдээ дараах аргачлалыг баримтална.

- 5.1.1. Үнэт цаас гаргагч нь ЗГДҮЦ-ны хуваарилалтыг арилжааны мэдэгдэлд заасны дагуу нэгдсэн үнэтэй арилжааны хэлбэр эсхүл ялгавартай үнэтэй арилжааны хэлбэрийн аль нэгээр хийнэ.
- 5.1.2. Ялгавартай үнэтэй арилжааны үед өрсөлдөөнт бус саналын хүү нь амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын жигнэсэн дундаж хүүтэй тэнцүү байна. Өрсөлдөөнт саналын хүү нь тухайн шууд оролцогчоос ирүүлсэн хүүний санал байна.
- 5.1.3. Нэгдсэн үнэтэй арилжааны үед өрсөлдөөнт бус болон өрсөлдөөнт саналын хүү нь амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын хамгийн өндөр хүү /таслагдсан хүү/-тэй тэнцүү байна.
- 5.1.4. Шууд оролцогч нь өөрийн санал болон шууд бус оролцогч бүрийн ЗГДҮЦ худалдан авах өрсөлдөөнт болон өрсөлдөөнт бус саналыг тусад нь арилжааны мэдэгдэлд заасан хугацаанд багтаан арилжаа эрхлэгч этгээдэд ирүүлнэ.
- 5.1.5. Хэрэв шууд болон шууд бус оролцогч нь хүү болон үнээрээ ялгаатай санал гаргах бол санал тус бүрээр тусад нь санал ирүүлнэ.
- 5.1.6. Арилжаанд оролцогч нь ЗГДҮЦ-ны өрсөлдөөнт санал буюу хүү (өгөөж)-ийн саналыг мянгатын нарийвчлалаар ирүүлнэ.
- 5.1.7. Арилжааны мэдэгдэлд купоны хувийг заагаагүй тохиолдолд купоны хувийг ялгавартай үнэтэй арилжааны үед амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын жигнэсэн дундаж утгаар, нэгдсэн үнэтэй арилжааны үед амжилттай биелсэн саналын таслагдсан утгаар тус тус тогтооно.
- 5.1.8. ЗГДҮЦ-ыг Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.3-т заасан зорилгоор арилжаалсан бол нэг шууд болон шууд бус оролцогчид арилжаалахаар зарласан ЗГДҮЦ-ны 25-аас илүүгүй хувийг, бусад зорилгоор арилжаалсан бол арилжаалахаар зарласан үнэт цаасны 50-иас илүүгүй хувийг хуваарилна.

- 5.1.9. Шууд болон шууд бус оролцогчдоос ирүүлсэн нийт санал нь арилжаалахаар зарласан хэмжээнд хүрэхгүй бол энэ аргачлалын 5.1.8-д заасан хязгаарыг арилжаалахаар зарласан хэмжээний 100 хувь хүртэл нэмэгдүүлж болно.
- 5.1.10. ЗГДҮЦ худалдан авах өрсөлдөөнт бус саналыг өрсөлдөөнт саналаас түрүүлж хуваарилах ба өрсөлдөөнт бус саналд тухайн арилжаагаар арилжаалахаар зарласан хэмжээний 30 хувийг хуваарилна.
- 5.1.11. Шууд оролцогчдоос ирүүлсэн өрсөлдөөнт бус саналын нийт хэмжээ өрсөлдөөнт бус саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс хэтрээгүй бол хуваарилалтыг шууд оролцогчийн ирүүлсэн саналаар хийнэ. Шууд оролцогчдоос ирүүлсэн өрсөлдөөнт бус санал нь тогтоосон хэмжээнээс давсан тохиолдолд хувь тэнцүүлэн хуваарилах буюу энэ журмын 5.1.14-д заасан томъёог ашиглан хуваарилалтыг хийнэ.
- 5.1.12. Өрсөлдөөнт бус хуваарилалтыг хийсний дараа арилжаанд оролцогчоос ирүүлсэн өрсөлдөөнт саналыг хүү /өгөөжийн хувь/-ний өсөх дарааллаар жагсаан, хамгийн бага хүүний саналаас эхлэн хуваарилалтыг хийнэ. Хэд хэдэн арилжаанд оролцогчийн ирүүлсэн ижил хүүний нийт саналын хэмжээ өрсөлдөөнт саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс давсан тохиолдолд энэ журмын 5.1.14-д заасан томъёог ашиглан хуваарилалтыг хийнэ.
- 5.1.13. Өрсөлдөөнт бус саналын хэмжээ өрсөлдөөнт бус саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс бага, өрсөлдөөнт саналын хэмжээ өрсөлдөөнт санал хуваарилахаар тогтоосон хэмжээнээс их тохиолдолд өрсөлдөөнт саналд хуваарилах хэмжээг арилжаалахаар зарласан хэмжээний 100 хувь хүртэл өсгөж болох бөгөөд ингэхдээ өрсөлдөөнт болон өрсөлдөөнт бус саналд хуваарилсан хэмжээ нь арилжаалахаар зарласан нийт хэмжээнээс хэтрэхгүй байна.
- 5.1.14. ЗГДҮЦ-ны арилжааны хувь тэнцүүлэн хийх хуваарилалтыг дараах томъёогоор тооцно.

$$P = \frac{B * V2}{V1}$$

P-Тухайн арилжаанд оролцогчид хуваарилах хэмжээ (бутархайн орныг бүхэлчилж тооцох бөгөөд )

V1-Арилжаанд оролцогчдын ирүүлсэн нийт саналын хэмжээ

V2-Арилжаанд оролцогчийн ирүүлсэн саналын хэмжээ

B- Зарласан нийт хэмжээ

- 5.1.15. ЗГДҮЦ-ыг бүхэл ширхгээр арилжаалах бөгөөд хувь тэнцүүлэн хуваарилалт хийхэд бутархайн орныг бүхэлчилж тооцно.
- 5.2. Үнэт цаас гаргагч нь хаалттай хэлбэрээр ЗГДҮЦ-ыг арилжаалахдаа энэ аргачлалын 5.1-д заасан аргачлалыг баримтлахгүй бөгөөд холбогдох хууль,

журамд нийцүүлэн тухайн арилжаанд оролцогчтой тохиролцсон дүнгээр арилжаална.

- 5.3. Үнэт цаас гаргагч нь ЗГДҮЦ-ыг хаалттай хэлбэрээр арилжаалахдаа зах зээлийн хүүний түвшнээс хэт өндөр хүүтэйгээр арилжаалахыг хориглоно.

## **ЗУРГАА. БУЦААН ХУДАЛДАН АВАХ**

- 6.1. ЗГДҮЦ-ыг буцаан худалдан авахдаа нээлттэй буюу урвуу дуудлага худалдаагаар, хаалттай буюу хөрөнгө оруулагчтай шууд харилцан тохиролцож буцаан худалдан авах аргуудыг ашиглана.

- 6.2. Буцаан худалдан авах ЗГДҮЦ-ны мэдэгдэлд буцаан худалдан авах үнэт цаасны дээд хэмжээ, өрсөлдөөнт болон өрсөлдөөнт бус саналд хуваарилах хэмжээ, санал хүлээн авах хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгана.

- 6.3. Нээлттэй буюу урвуу дуудлага худалдаагаар ЗГДҮЦ-ыг буцаан худалдан авахдаа дараах аргачлалыг баримтална.

6.3.1. Үнэт цаас гаргагч нь нээлттэй буцаан худалдан авах ЗГДҮЦ-ны мэдэгдлийг 2 долоо хоногоос доошгүй хугацааны өмнө өөрийн цахим хуудас болон арилжаа эрхлэгч этгээдээр дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

6.3.2. Шууд оролцогч нь өөрийн санал болон шууд бус оролцогч бүрийн ЗГДҮЦ зарах өрсөлдөөнт болон өрсөлдөөнт бус саналыг тусад нь арилжааны мэдэгдэлд заасан хугацаанд багтаан арилжаа эрхлэгч этгээдэд ирүүлнэ.

6.3.3. Арилжаанд оролцогч нь ЗГДҮЦ-ны өрсөлдөөнт санал буюу хүү (өгөөж)-ийн саналыг мянгатын нарийвчлалаар ирүүлнэ.

6.3.4. Үнэт цаас гаргагч нь ЗГДҮЦ буцаан худалдан авах арилжааны хуваарилалтыг энэ журмын 5.1.2-д заасан ялгавартай үнэтэй арилжааны хэлбэрээр хийнэ.

6.3.5. Нэг шууд болон шууд бус оролцогчид буцаан худалдан авахаар зарласан үнэт цаасны 50-иас илүүгүй хувийг хуваарилна. Хэрэв бусад шууд болон шууд бус оролцогчдоос ирүүлсэн нийт санал нь буцаан худалдан авахаар зарласан хэмжээнд хүрэхгүй бол энэ хязгаарыг буцаан худалдан авахаар зарласан үнэт цаасны 100 хувь хүртэл нэмэгдүүлж болно.

6.3.6. ЗГДҮЦ зарах өрсөлдөөнт бус саналыг өрсөлдөөнт саналаас түрүүлж хуваарилах ба өрсөлдөөнт бус саналд тухайн арилжаагаар буцаан худалдан авахаар зарласан хэмжээний 15 хувийг хуваарилна.

6.3.7. Шууд оролцогчдоос ирүүлсэн өрсөлдөөнт бус саналын нийт хэмжээ өрсөлдөөнт бус саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс хэтрээгүй бол хуваарилалтыг шууд оролцогчийн ирүүлсэн саналаар хийнэ. Шууд оролцогчдоос ирүүлсэн өрсөлдөөнт бус санал нь тогтоосон хэмжээнээс давсан тохиолдолд хувь тэнцүүлэн хуваарилах буюу энэ журмын 5.1.14-д заасан томъёог ашиглан хуваарилалтыг хийнэ.



- 6.3.8. Өрсөлдөөнт бус хуваарилалтыг хийсний дараа арилжаанд оролцогчоос ирүүлсэн өрсөлдөөнт саналыг хүү /өгөөжийн хувь/-ний буурах дарааллаар жагсаан, хамгийн өндөр хүүний саналаас эхлэн хуваарилалтыг хийнэ. Хэд хэдэн арилжаанд оролцогчийн ирүүлсэн ижил хүүний нийт саналын хэмжээ өрсөлдөөнт саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс давсан тохиолдолд энэ журмын 5.1.14-д заасан томъёог ашиглан хуваарилалтыг хийнэ.
- 6.3.9. Өрсөлдөөнт бус саналын хэмжээ өрсөлдөөнт бус саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс бага, өрсөлдөөнт саналын хэмжээ өрсөлдөөнт санал хуваарилахаар тогтоосон хэмжээнээс их тохиолдолд өрсөлдөөнт саналд хуваарилах хэмжээг буцаан худалдан авахаар зарласан хэмжээний 100 хувь хүртэл өсгөж болох бөгөөд ингэхдээ өрсөлдөөнт болон өрсөлдөөнт бус саналд хуваарилсан нийт хэмжээ нь буцаан худалдан авахаар зарласан хэмжээнээс хэтрэхгүй байна.
- 6.4. Үнэт цаас гаргагч нь ЗГДҮЦ-ыг хаалттай буцаан худалдан авах тохиолдолд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг үндэслэнэ.
- 6.5. Үнэт цаас гаргагч нь ЗГДҮЦ-ыг хаалттайгаар буцаан худалдан авахдаа зах зээлийн хүүгээр хувиар өнөөгийн үнэ цэнийг тооцон буцаан худалдан авах, хуримтлагдсан хүүгийн төлбөрийг үндсэн төлбөрийн хамт төлөх аргуудыг ашиглаж болно.
- 6.6. ЗГДҮЦ-ыг хаалттайгаар буцаан худалдан авахдаа хямдруулалтын хүүг зах зээлийн хүүгээс өндрөөр тооцох, тухайн ЗГДҮЦ-ыг зах зээлийн үнээс өндрөөр үнэлэн буцаан худалдан авахыг хориглоно.